



**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд
олон нийтийн оролцоог хангах зорилгоор
гарын авлага боловсруулж, цахим сургалт
зохион байгуулах нь**

Үйл ажиллагааны товч тайлан
2022 он

Мэдэгдэл

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэ тайланд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэ тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч

АМЕП 2 хөтөлбөрийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэшнл зөвлөх компани хэрэгжүүллээ.

Adam Smith
International

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах зорилгоор зөвлөмж боловсруулж, цахим сургалт зохион байгуулах зөвлөх үйлчилгээ: Зөвлөх үйлчилгээний тайлан

Монгол Улсын Засгийн газар, Австрали Улсын Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕП/-өөс Байгаль орчин, аялал жуулчлалын яам /БОАЖЯ/-ны захиалгаар “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд /БОНБУ/ олон нийтийн оролцоог хангахад дэмжих” төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд “Монголын Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл” ТББ-ын зөвлөх баг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор гарын авлага боловсруулж, цахим сургалт зохион байгуулах зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэв.

Ингэхдээ БОНБУ-ий явцад орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах арга зам, мэдээлэл бүрдүүлэлтийн талаар одоо байгаа гарын авлага, зөвлөмжийг судлан, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны зэрэгцээ энэ ажлын хүрээнд өмнө АМЕП хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн тайлангуудын үр дүнд тулгуурлан, гарын авлага, цахим сургалтын модулийг боловсруулав.

Тайлан боловсруулсан: Монголын Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл /ТНЗ/ ТББ

ТНЗ нь 2015 онд Монголын уул уурхайн тэргүүлэгч компаниудын тогтвортой хөгжил, байгаль орчин, орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын мэргэжилтнүүдийн санаачилгаар байгуулагдсан ашгийн бүс нийгэмд үйлчлэх ТББ болно.



2022 оны 06 сарын 15

Эцсийн тайлан хүлээн авалцсан баримт

Илгээсэн огноо	
Илгээгч	
Хүлээн авагч	
Гарын үсэг	
Батлав	
Гарын үсэг	
Огноо	

Судлаач, гэрээлэгч тайлангийн эхний хувилбарыг АМЕП 2 хөтөлбөрийн Менежерт илгээх бөгөөд илгээсэн хувилбар бүрт дараах хүснэгтийг бөглөсөн байна.

Илгээсэн огноо	2022.06.16
Хэнд	П.Оюунбилэг
Гарын үсэг	
Хэнээс	Н.Ариунтуяа

Агуулга

Зургийн жагсаалт	6
Графикийн жагсаалт	6
Хүснэгтийн жагсаалт	6
Үйл ажиллагааны товч тайлан	7
1. Зөвлөх үйлчилгээний талаарх ерөнхий мэдээлэл	7
1.1 Төслийн танилцуулга	7
1.2 Төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц	8
2. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” гарын авлага	9
2.1 Гарын авлагын агуулга	9
2.2 Гарын авлагын бүтэц	9
2.3 Гарын авлагыг боловсруулахдаа анхаарсан асуудлууд	11
3. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” цахим сургалтын тайлан	13
3.1 Сургалтын бэлтгэл ажил	13
3.1.1 Оролцогчдыг тодорхойлох, зар хүргэх	14
3.1.2 Сургалтын модуль, хөтөлбөр	15
3.1.3 Сургалтын өмнөх мэдлэгийн тест	15
3.2 Сургалтын үйл явц	17
3.3 Цахим сургалтын үеэр гарсан нийтлэг асуултууд	21
3.4 Сургалтын үнэлгээ, сэтгэгдэл	21
3.5 Цахим сургалтын сорилт, бэрхшээл, суралцсан зүйлс	23
4 Мэдээллийн сангийн мониторингийн үр дүн	26
5 Эрх зүйн орчныг сайжруулах, зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмж	28
6 Хавсралт	32
6.1 Гарын авлага	32
6.2 Оролцогч талуудын жагсаалт	32
6.3 Цахим сургалтын модуль	32
6.4 Цахим сургалтын хөтөлбөр	32
6.5 Цахим сургалтад оролцогчдын жагсаалт	32
6.6 Мэдээллийн сангийн мониторинг	32

Товчилсон үгийн жагсаалт

АМЕП	Австрали Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОННУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ЗЗНДНТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБХ	Нүүрснээс нийлэг байгалийн хий
ЕҮД	Ерөнхий үнэлгээний дүгнэлт
ОХУ	Оросын Холбооны Улс
СНҮ	Стратегийн нөлөөллийн үнэлгээ
ТНЗ	Монголын тогтвортой хөгжлийн нийгмийн хариуцлагын зөвлөл ТББ
ТБУ	Төлөв байдлын үнэлгээ

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын явцын зураглал

Зураг 2. Гарын авлагын бүтэц

Зураг 3. Сонгогдсон аймаг, сум, багийн мэдээлэл

Зураг 4. Сургалтын явц Хэнтий аймаг

Зураг 5. Сургалтын явц Сүхбаатар аймаг

Зураг 6. Сургалтын явц Өвөрхангай аймаг

Графикийн жагсаалт

График 1. Мэдлэг шалгах төстийн нэгтгэл

График 2. Сургалтад оролцогчдын мэдээлэл аймаг, хүйсээр ангилсан

График 3. Сургалтад оролцогчдын ажил мэргэжил, албан тушаалын бүтэц

График 4. Сургалтад хэрэглэгдсэн төхөөрөмжийн тоо

График 5. Үнэлгээний хуудасны нэгтгэл

График 6. Сургалтын үр дүнгийн үнэлгээ

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Мэдлэг шалгах төстийн нэгтгэл

Хүснэгт 2. Үнэлгээний хуудасны нэгтгэл

Үйл ажиллагааны товч тайлан

1. Зөвлөх үйлчилгээний талаарх ерөнхий мэдээлэл

1.1 Төслийн танилцуулга

Зөвлөх үйлчилгээний хэрэгцээ шаардлага:

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-нд олон нийтийн оролцоог хангах, мэдээллийг ил тод нээлттэй болгох, мэдэх эрхийг хангах ажилд гарч буй хүндрэл, оролцогч талуудын хооронд үүсээд буй зөрчлүүдийг арилгахын тулд олон талт оролцоог хангах, хариуцсан салбарын төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, орон нутгийн удирдлага, иргэдийг мэдээллээр хангах, чадавхжуулах.

Зөвлөх үйлчилгээний чиглэл:

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор гарын авлага боловсруулж, цахим сургалт зохион байгуулах.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

- БОННУ-ний явцад орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах арга зам, мэдээлэл бүрдүүлэлтийн талаар одоо байгаа гарын авлага, зөвлөмж, энэ ажлын хүрээнд өмнө АМЕП хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн тайлангуудыг судлан, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлов.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад шаардлагатай хэрэгцээт мэдээллээр хангах Гарын авлага, цахим сургалтын модуль боловсруулав.
- Гарын авлагын агуулга, цахим сургалтын модульд тулгуурлан, цахим сургалт зохион байгуулах аймаг, сумдыг (Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай 3 аймаг болон сумд) БОАЖЯ болон АМЕП хөтөлбөртэй хамтран сонгож, сургалт зохион байгуулав.
- Байгаль орчны мэдээллийн сангаас туршилтын 3 аймагт хэрэгжиж буй болон хэрэгжих БОННУ тайлангаа батлуулсан төслүүдийн мэдээллийг шүүж нэгтгэж, Байгаль орчны хуулиудаар төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутагт хүлээлгэж өгөх үүрэгтэй баримт бичгүүдийн бүрдлүүдийг гаргаж, аймгийн БОАЖГ болон сумдуудын ЗДТГ-тай хамтран тулгах ажил хийв.
- Хийсэн ажлын тайланг БОННУ-д олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулах, зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмжийн хамт боловсруулав.

Зөвлөх үйлчилгээний оролцогч талууд:

БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах, мэдээллийг ил тод нээлттэй болгох, мэдэх эрхийг хангах ажилд гарч буй хүндрэл, оролцогч талуудын хооронд үүсээд буй зөрчлийг арилгахад олон талт оролцоог хангах, хариуцсан салбарын төрийн захиргааны байгууллага, БОННУ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, орон нутгийн удирдлага, албан

тушаалтан, иргэдийг чадавхжуулах, мэдээллээр хангах ажлаас эхлэх шаардлага байгааг энэхүү ажлын хүрээнд судалсан судалгааны зөвлөмжүүд илтгэж байна.

Дурдсан судалгаануудад БОННУ дэх олон нийтийн оролцоо болон мэдэх эрхийн асуудлаар хамгийн ихээр санал хүсэлтээ илэрхийлж, мэдлэг, мэдээллээ сайжруулах шаардлагатай байгаа тухай шүүмж хэлж байсан оролцогч талуудыг эхний ээлжинд чадавхжуулах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- Орон нутгийн өөрөө удирдах байгууллага
- Орон нутгийн төр захиргааны байгууллага
- Орон нутгийн иргэд
- Иргэний нийгмийн байгууллага багтаж байна.


Зөвлөх үйлчилгээнээс хүлээж буй үр дүн:

Иргэд, орон нутгийн удирдлага олон нийтийн оролцооны ач холбогдлыг ойлгож, ИНХ-ын үр ашгийг дээшлүүлэх, оролцоогоо хангах, мэдэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой болно.

1.2 Төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц

Зөвлөх үйлчилгээ нь 2022 нэгдүгээр сараас эхлэн зургаадугаар сарыг дуустал нийт 6 сарын хугацаанд хэрэгжив. Энэ хүрээнд гүйцэтгэсэн ажлын явцыг дараах зураглалаас харна уу.

Зураг 1. Төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын явцын зураглал



2. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” гарын авлага

2.1 Гарын авлагын агуулга

Гарын авлагын агуулгыг боловсруулахдаа 2021 онд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП-2) хүрээнд боловсруулсан судалгаануудын дүгнэлтэд үндэслэн, үндсэн агуулга, анхаарах сэдвүүдийг тодорхойлов. Ингэхдээ дараах гол дүгнэлтүүдэд тулгуурлан, мэдээллийн эрэлт хэрэгцээг хангахыг зорьж ажиллалаа.


- ИНХ-аар зөвхөн үнэлгээний тайланг хэлэлцэхээр ээлжит бус хурал зохион байгуулах тохиолдол маш цөөн. Ихэнхдээ ИНХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах байдлаар үнэлгээний тайланг хэлэлцүүлж байна. Орон нутгийн “дотоод” асуудлаа хэлэлцэж дуусаад үнэлгээний тайлангийн танилцуулгыг сонсож хэлэлцдэг жишиг нийтлэг байна. Иргэдэд зар мэдээ хүргэх, тайлангийн мэдээлэл, түүнийг уншиж ойлгоход шаардлагатай хугацаа олгох талаар зохицуулалт журамд байхгүй.
- ИНХ-ын үнэлгээний хэлэлцүүлгийг одоогийн жишгээр ээлжит хурлаар хийх үү, ээлжит бус хурал зарлаж хийх үү, үнэлгээний урьдчилсан мэдээллийг хэн, ямар хэлбэрээр, хэзээ иргэдэд хүргэх вэ, орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг хариуцлага ямар байх гэдэг асуултуудыг хууль, журамд тодорхой тусгаагүйн улмаас иргэдийн оролцоог хангахад бэрхшээл тулгарч байна.
- Мэдээллийн ил тод байдал, хүртээмж БОННУ-ний бүхий л үе шатны холбогдох мэдээллийг цаг тухай бүрд иргэдэд ил тод, хүртээмжтэй хэлбэр, арга, агуулгаар хүргэх хэрэгцээ маш их байна.
- Үнэлгээ хийх төслийн ангиллыг нарийвчилж үзэх, түүний дагуу оролцооны шаардлагуудыг ялгаатай тусгах, үнэлгээний эхлэлээс батлагдах хүртэлх олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг тодорхой болгох, БОННУ-ний талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг сайжруулах, үнэлгээний мэдээллийн хүртээмжтэй байдлыг сайжруулах хэрэгтэй.

Дээрх хэрэгцээнд тулгуурлан, гарын авлагын бүтцийг дараах байдлаар гаргав.

2.2 Гарын авлагын бүтэц

Гарын авлагын 1, 2 дугаар бүлэгт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе шатууд болон хууль, эрх зүйн баримт бичгүүдийн талаарх холбогдох мэдээллүүдийг хүргэхийг эрмэлзсэн бол 3 дугаар бүлэгт олон нийтийн оролцоог хангахад оролцогч талуудын эрх үүрэг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн сайжруулах талаарх хууль, журам, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн судалгаа, гарын авлага материал дээр үндэслэн хэрэгцээт мэдээллүүдийг хуваалцав. 4 дүгээр бүлэгт газрын хэвлийн баялаг ашиглах төслүүдээс байгаль орчинд үзүүлж буй болон болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод байлгах, иргэдийн үндсэн хуульд заасан мэдэх эрхээ хангах хууль, эрхзүй, мэдээллийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл багтав. *Гарын авлагын PDF хувилбарыг хавсаргав.*

Зураг 2. Гарын авлагын бүтэц



2.3 Гарын авлагыг боловсруулахдаа анхаарсан асуудлууд:

Аргачлалын хувьд

- Онолын мэдээлэл буюу БОНБУ-д олон нийтийн оролцоог хангах журмын хэрэгжилтийг ОУ болон үндэсний сайн туршлагатай уялдуулан холбож боловсруулав.
 - Иргэдийн оролцооны суурь зарчим, холбогдох хуулиудын талаарх мэдээллүүдийг шигтгэж оруулав.
 - Иргэдийн оролцооны ач холбогдол, идэвхжүүлэх алхмыг хүснэгт, график, сайн туршлага, түүх бичих байдлаар тусгав.
 - ИНХ-ыг үр дүнтэй чиглүүлэн зохион байгуулах зөвлөмжийг энгийн зурган байдлаар оруулав.
 - Мэдээллийг хүргэж буй олон улсын туршлагаас хуваалцав.
1. БОННУ-ний тайлангийн төслийг ИНХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаар хэлэлцүүлдэг зохицуулалт зөвхөн Монгол улсад хэрэгждэг. Судлаачдын онцолж байгаагаар энэ нь үнэлгээний тайланг танилцуулах, иргэдээс санал авах ажлын зохион байгуулалт тодорхой бус болох, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх зэрэг хүндрэлүүдийг үүсгэсээр байгаа ч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журмын хүрээнд БОННУ-нд иргэдээс санал авах үйл ажиллагааг хэрхэн сайжруулж болох тухай аргачилсан зөвлөмжийг алхам бүрээр нь хүргэв.
 2. Үүний хамт БОННУ-ний тайланд олон нийтийн оролцоог хэрхэн хангаж ажилласан талаарх бодит жишээг дэлгэрэнгүйгээр оруулав. Оролцоог үе шат бүрд үлгэр жишээ хангаж ажилласан харьцангуй том төслийн жишээ сонгох нь зүйтэй гэж үзсэн. Ингэснээр жижиг, дунд төсөл дээр орон нутгийнхаа онцлог, нөхцөл байдалтай уялдуулан үе шат бүрийг хангаж ажиллахад туршлага болох юм.

Шигтгээ 1

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийг оролцуулсан сайн туршлагын жишээ

Энэ нь Улаанбаатар хотын захын оршин суугчид, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг газруудын түүхий нүүрсний шаталтаас үүсэж буй агаарын бохирдлыг бууруулах зорилготой “Нүүрснээс нийлэг байгалийн хий (НБХ) гарган авах үйлдвэр” байгуулах төсөл болно. Төсөл нь Дэлхийн банкны санхүүжилтээр “Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн хүрээнд хэрэгжсэн. Уг төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2016-2019 онд үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “Грийнтрэндс” ХХК-ийн зөвлөх баг боловсруулсан.

Ингэхдээ Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам” болон Дэлхийн банкны “Олон нийтийн хэлэлцүүлэг, Мэдээллийн нээлттэй байдлын тухай” журмын дагуу Нүүрснээс НБХ гарган авах үйлдвэр байгуулах төслийн БОННУ-ний төслийг тухайн үйлдвэр болон хий дамжуулах шугам хоолой баригдах нөлөөллийн бүсэд хамаарагдах орон нутгийн холбогдох оролцогч талуудад ил тод, нээлттэй хэлэлцүүлэн, БОННУ-ний

тайлангийн төсөлд санал зөвлөмжийг нь авчээ. Энэхүү БОННУ тайланд хэрхэн олон нийтийн саналыг тусгаж ажилласан талаарх бодит жишээг хүргэсэн.


3. Олон нийтийн оролцоог хангах талаарх бүлэгт оролцогч талууд ямар хууль, журмын ямар заалтаар ямар эрх, үүрэг хүлээж байгааг нэг дороос шууд харахын зэрэгцээ түвшин, түвшинд харьцуулж харах боломжтойгоор хялбаршуулан схемчлэв.
4. Оролцогч талуудын тэгш, хүртээмжтэй байдлыг хангахын тулд оролцогч талуудаа хэрхэн тодорхойлох, оролцогч талуудын зураглалыг хэрхэн гаргах практик зөвлөмжийг олон улсын түвшинд оролцогч талуудын матриц гаргадаг талаарх мэдээлэлтэй харьцуулж оруулав.
5. Үнэлгээний тайланд иргэдээс санал авах ажлын үр дүнг нэмэгдүүлэх үүднээс үнэлгээний тайлан хэлэлцүүлэхэд хурлын дэг, үргэлжлэх хугацаа, хэлэлцүүлгийн зорилго зорилтыг иргэдэд танилцуулах, иргэдийн саналыг нээлттэй эсвэл хаалттай авах зэрэгт сайжруулалт хийх шаардлага зүй ёсоор байсаар байгаа тул хэлэлцүүлгийн үр нөлөөг хэрхэн сайжруулж болох талаарх саналыг мөн багтаав.
6. Мөн хэлэлцүүлгийн үеэр гарч болох маргаан зөрчлөөс сэргийлэх зөвлөмжийг тусгасан.
7. Баг, хорооны ИНХ-ын шийдвэр гаргах, эс гаргах болон үүнийг далимдуулж, шантааж хийх, авилгын хэлбэрийн зүйлс шаардах, үндэслэлгүйгээр хуралдахгүй байх, хууль бусаар хуралдах, түүнээс үүдсэн эрсдэлийн талаар оруулж өгсөн.
8. Мэдээлэл авах эх сурвалжуудыг тодорхой зааж өгсөн. /Аймаг, сум, мэдээллийн сангууд болон бусад/
9. Төслийн онцлог, хүчин чадал, төрлөөс хамаарч хэрхэн уян хатан байлгах, аль төсөлд юуг анхаарах, иргэний эрх хаана хөндөгдөх, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд юуг мэдвэл зохих зэрэг зөвлөгөөг оруулав.

3. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” цахим сургалтын тайлан

3.1 Сургалтын бэлтгэл ажил

Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд бэлтгэсэн гарын авлагын агуулгыг үндэслэн цахим сургалтын модуль боловсруулсан болно. Уг модулийг ашиглан цахим сургалт зохион байгуулах 3 аймгийг БОАЖЯ-ны зүгээс санал болгосноор сонгов.

Зураг 3. Сонгогдсон аймаг, сум, багийн мэдээлэл



Аймгуудыг сонгосон үндэслэл:

Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн нэгжийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй санал солилцож, тухай аймгуудын хөгжлийн төлөвлөлт, байршил, уул уурхай болон бусад төслүүдийн онцлог, мөн олон улсын бусад төсөл хэрэгжиж байгаа эсэх зэргийг ерөнхий шаардлага болгон сонгосон. Тухайлбал:

- Сүхбаатар аймаг нь уул уурхай, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул эрчимтэй явагдаж буй Монгол Улсын хилийн боомт байрлаж буй цаашид стратегийн хувьд эрчимтэй хөгжих нөхцөлийг харгалзсан.
- Хэнтий аймаг нь Бор-Өндөр, Бэрх, Чандгана гэх зэрэг олон жилийн өмнөөс уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явж буй, шинээр цөөнгүй төслүүд хэрэгжихээр төлөвлөгдсөн, мөн Монгол Улсын Засгийн газраас түүхэн аялал жуулчлалын хөгжлийн төв байхаар стратегидаа тусган ажиллаж байгаа тул уул уурхай болон бусад төслийг аялал жуулчлалын төслүүдтэй уялдуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг харгалзсан.
- Өвөрхангай аймаг нь Баруун-Төвийн бүсэд хамаарах уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал хөгжих төвийн бүсийн аймгийн төлөөлөх аймаг болно.

3.1.1 Оролцогчдыг тодорхойлох, зар хүргэх

Цахим сургалтын бэлтгэл ажил 2 дугаар сараас эхэлсэн. Цахим сургалтад аймаг тус бүрээс Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох албан тушаалтнууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл болон сум, багийн засаг дарга нарыг оролцуулахаар тодорхойлов. Тодорхойлсон оролцогчдын жагсаалтыг 3 аймгийн түвшинд урьдчилан гаргасан.

3 дугаар сарын 1-ний өдөр тодорхойлсон оролцогчдын жагсаалтын дагуу сургалтын мэдээлэл, танилцуулгыг емайлаар хүргүүлсэн.

Мөн гарын авлага, цахим сургалтын аргачлалыг илүү үр дүнтэй болгохын тулд ямар мэдлэг, мэдээллийг ямархуу арга замаар хүргэвэл оновчтой байх талаар саналын хуудас бэлтгэж хамтатган хүргүүлэв. Нийт 465 хүнд емайл явуулснаас 8 сумаас 26 хүнийг төлөөлсөн хариу ирж, оролцохоо мэдэгдсэн болно.

2022 оны 5 дугаар сарын 19-нд Хэнтий аймаг, 5 дугаар сарын 26-нд Сүхбаатар аймагт, 5 дугаар сарын 30-нд Өвөрхангай аймагт тус тус зохион байгуулахаар сургалтын товыг тогтож, бэлтгэл ажлыг хангав. 5 дугаар сарын 2-ноос аймаг тус бүрийн ЗДТГ болон БОАЖГ, сумдын Засаг дарга нартай холбогдсоны үндсэн дээр 2 дугаар сард урьдчилан гаргасан жагсаалтыг шинэчилж, оролцогчдыг шинээр бүртгэв.

Сургалтын зар, мэдээлэл хүргэх ажлын хүрээнд:

1. Сургалтын зар мэдээллийг аймгийн ЗДТГ, БОАЖГ-ын удирдлага болон 50 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нартай нэг бүрчлэн утсаар ярьж мэдэгдэв. Мөн цахим хаягаар нь сургалтын хөтөлбөр, оролцогчдын урьдчилсан лист, сургалтын өмнөх мэдлэг шалгах тестийн маягтыг урьдчилан хүргүүлж, дахин утсаар ярьж баталгаажуулсан.
2. Сум тус бүрийн Засаг даргад хүсэлт тавьж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх ажилтныг томилуулсан. Томилогдсон ажилтантай хамтран оролцогчдын мэдээллийг шинэчлэн бүртгэв. Хариуцсан ажилтанд оролцогч бүрт хэрхэн нэг бүрчлэн мэдээлэл хүргэх талаар зөвлөмж заавар өгсөн. Сургалтад оролцуулах тухай аймгийн БОАЖГ-ын даргад хандсан БОАЖЯ-ны албан тоотын хамт, сургалтын зар, сургалтын хөтөлбөр, холбогдох бусад мэдээллийг цахимаар хүргүүлэв.

Сургалтын техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл хангах ажлын хүрээнд:

1. Бүртгүүлсэн хүмүүсийг бүрэн хамруулах, тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор сумаас оролцох иргэдийг сумын ЗДТГ-ын хурлын танхим болон иргэний танхимд цуглуулан нэг дороос хамт оролцох зохион байгуулалт хийсэн. Ингэснээр 3 аймгаас нийт 441 оролцогч 172 төхөөрөмжөөс сургалтад оролцов.
2. Сургалтын өмнөх өдөр аймаг тус бүрээс оролцох тоног төхөөрөмжийн судалгааг авч, техникийн урьдчилсан тест хийж шалгав.

Сургалтад оролцогчдын мэдлэгийг шалгах тест болон сургалтын үнэлгээний хуудас бөглүүлэх ажлын хүрээнд:

1. Сургалтад оролцогч тус бүрээс БОННУ-ний талаар сургалтын өмнө болон сургалтын дараах мэдлэг шалгах тестийг авахаар бэлтгэн, оролцогчдод зар мэдээллийн хамт хүргүүлсэн. Сургалтын өмнөх тестийг сургалтаас өмнө авахаар зохион байгуулсан.
2. Сургалт эхлэхээс өмнө сургалтын дараах тест болон сургалтын үнэлгээ ирүүлэх талаарх мэдээллийг урьдчилан өгч, холбогдох маягтуудыг хариуцсан ажилтан тус бүрийн емейлаар илгээн, урьдчилан хэвлүүлж бэлтгэсэн.
3. Сургалтын дараа тест бөглөх цаг гаргаж, тест болон сургалтыг үнэлэх үнэлгээний хуудсыг бөглүүлэх зохион байгуулалт хийсэн.

3.1.2 Сургалтын модуль, хөтөлбөр

Нийт дөрвөн цагийн сургалтын хөтөлбөр бэлтгэж, түүний дагуу дараах сэдвийн хүрээнд сургалтын модулийг бэлтгэсэн. Үүнд:

- БОНУ-ний тогтолцоо, үе шат ба хууль журам:
 - БОНУ, түүний тогтолцоо үе шат
 - БОНУ, хууль ба журам
- БОНУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай
 - Яагаад иргэдийг БОНУ-д оролцуулах ёстой вэ?
 - БОНУ-нд оролцогч талууд
 - Олон нийтийн оролцоог хангах үе шат
 - Олон нийтийн хэлэлцүүлгийг үр дүнтэй зохион байгуулах

Сургалтын хөтөлбөр, модулийг хавсаргав.

3.1.3 Сургалтын өмнөх мэдлэгийн тест

Сургалтын агуулгын хүрээнд оролцогчдоос мэдлэгийн түвшинг тандах зорилгоор 19 асуулт бүхий тестийг бөглүүлэв.

Нийт 441 оролцогчоос 123 оролцогч буюу 28 хувь нь сургалтын өмнөх мэдлэгийн тестийг бөглөсөн. Энэ нь хэдийгээр хангалттай хувь биш боловч 3 аймгийн төлөөлөл оролцсон учраас уг тестийн нэгтгэлийг хийж сургалтын хэрэгцээт байдлыг тодорхойлох боломжтой гэж үзлээ.

Тестийн (хүснэгт 1) эхний 4 асуултын хүрээнд оролцогчид өөрсдийн ажил мэргэжлийн хүрээнд тодорхой хэмжээний мэдээлэлтэй нь харагдаж байна. Харин 5-19 дүгээр асуултад дийлэнх оролцогчид буруу хариулжээ. Тухайлбал, БОННУ-ний тайлан боловсруулах, хэлэлцүүлэх үе шатанд иргэдийг оролцуулах тухай асуултуудад оролцогчид ихэнхдээ буруу хариулсан байна. Тестийн нээлттэй асуултад (12, 17-19) дийлэнх оролцогчид хариулаагүй, саналаа бичсэн хүмүүсийн дийлэнх нь дутуу хариулсан байсан.


Сургалтын өмнөх мэдлэгийн тестийг ашиглан сургалтын дараа дахин энэ тестийг авах гэж зохион байгуулагчдын зүгээс хичээсэн боловч 3 аймгаас хангалттай мэдээлэл өгөөгүй тул сургалтын дараах мэдлэгийн тестийн дүгнэлтийг хийгээгүй болно.

Хүснэгт 1. Мэдлэг шалгах тестийн нэгтгэл

№	Асуулт	Зөв	Буруу
1	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хэдэн төрөл байдаг вэ?	62	61
2	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хэн гүйцэтгэх вэ?	89	34

3	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зорилго юу вэ?	92	31
4	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг ямар байгууллага баталдаг вэ?	85	38
5	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хэдэн хувь боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлдэг вэ?	24	99
6	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах аль үе шатанд иргэдийн саналыг тусгадаг вэ?	13	110
7	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах аль үе шатанд багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, саналыг авдаг вэ?	22	101
8	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах шатанд иргэд оролцох ямар ач холбогдолтой вэ?	24	99
9	Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.” заалтын хэрэгжилтийг хэн хангах үүрэгтэй вэ?	47	76
10	Оролцогч талуудын хэн нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүрэг хүлээдэг вэ?	20	103
11	Иргэд олон нийт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн талаарх гомдол, маргааныг хэнд хандаж гаргах вэ?	19	104
12	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулах шатанд олон нийтийн оролцоог хангахын тулд юу хийх вэ?	47	76
13	БОНУ-ний тайланд олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын хэдэн өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авах шаардлагатай байдаг вэ?	30	93
14	ИНХ-ын хуралдааны товыг тухайн баг, хорооны оршин суугчдад хэдэн өдрийн өмнө мэдээлэх ёстой вэ?	13	110
15	ИНХ-ыг зохион байгуулах дэгд юу юуг тусгах ёстой вэ?	15	108
16	Хэлэлцүүлгийн үеэр иргэдийн саналыг ямар хэлбэрээр авах нь зохимжтой вэ?	18	105
17	БОНУ тайланд санал өгөхтэй холбоотой ямар асуудлуудыг тусгах шаардлагатай вэ?	11	112
18	ИНХ-ын хэлэлцүүлгийг зохион байгуулах явцад зохион байгуулагч оролцогчдын дунд заримдаа маргаан зөрчил гардаг. Тийм тохиолдолд та юу хийх вэ?	14	109
19	Хэлэлцүүлгийн тайланд тусгах зүйлсийг бичнэ үү.	12	111


График 1. Мэдлэг шалгах тестийн нэгтгэл



3.2 Сургалтын үйл явц


Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах цахим сургалтыг 2022.05.19, 05.26, 05.30-ны өдрүүдэд зорилтот гурван аймагт төлөвлөсний дагуу амжилттай зохион байгуулсан. Сургалтад БОАЖЯ болон АМЕП хөтөлбөр, зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэгч багийн төлөөлөл, холбогдох мэргэжилтнүүд оролцов.

График 2. Сургалтад оролцогчдын мэдээлэл аймаг, хүйсээр




Нийт 4 цагийн хугацаанд ТНЗ-ийн зөвлөх Б.Баяржаргал, Ж.Чанцалдулам нар хамтран сургалтыг чиглүүлж явуулсан. Мөн Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн дарга Г.Батхишиг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сангийн талаарх мэдээллийг аймаг тус бүрийн түвшинд танилцуулсан.


Зураг 4. Сургалтын явц Хэнтий аймаг



Зураг 5. Сургалтын явц Сүхбаатар аймаг



Зураг 6. Сургалтын явц Өвөрхангай аймаг




Сургалтын материалд хууль, журмын мэдээлэл, оролцогч талуудын санал дүгнэлт, судалгаанд суурилсан практик зөвлөмжийг багтаасан. Сургалт нь мэдлэг шалгах, сэдэлжүүлэх дасгал ажил, ур чадвар дээшлүүлэх багийн ажил, мэдлэг олгох ба мэдээлэл өгөх, мэдлэг бататгах дүгнэлт хэсгээс бүрдсэн.

Сургалтыг сайн туршлага, мэдээлэл, дүн шинжилгээ хийх, оюуны дайралт, багаар ажиллах, тоглоомын арга, асуулт хариулт, видео, үзүүлэн материал ашиглах аргыг ашиглан зохион байгуулав.

Цахим сургалтад төслийн хүрээнд сонгогдсон Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймгуудын нийт 50 сумын 268 баг, тосгоноос БОННУ хийхэд оролцогч бүх талуудын төлөөллийг хамруулах зорилт тавин ажилласан бөгөөд нийт 441 оролцогчтойгоор сургалтыг зохион байгуулсан.


График 3. Сургалтад оролцогчдын ажил үүрэг, албан тушаал



Нийт сургалтад оролцогчдын 58.7% нь баг, тосгоны засаг дарга нар байв.

График 4. Сургалтад хэрэглэгдсэн төхөөрөмжийн тоо

Цахим сургалтад оролцогчид нийт 172 төхөөрөмжөөс хандан оролцсон. Үүнд: Хэнтий аймгаас 69, Сүхбаатар аймгаас 45, Өвөрхангай аймгаас 58 төхөөрөмжөөр тус тус холбогдсон бөгөөд нэг төхөөрөмжөөс дунджаар 3 хүн холбогдсон дүнтэй байна.



3.3 Цахим сургалтын үеэр гарсан нийтлэг асуултууд

- Уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагууд иргэдээс санал авахгүй нарийвчилсан үнэлгээ хийлгэж, батлуулан, тусгай зөвшөөрөл авч байна. Үүнд хаанаас хяналт тавьж, хариуцлага тооцдог вэ? Ийм зөрчлийн талаар хаана, хэнд хандах вэ?
- БОННУ-нд КОВИД-19 цар тахлын үеэр цахимаар санал авах тухай зохицуулалт гарсан уу? Гарсан бол хаанаас хэн шийдвэрлэсэн бэ?
- Сургалтын материалуудыг жишээ баримтуудын хамт авч болох уу?
- Сургалтад танхимаар хамрагдах хүсэлтэй байна.
- Мэдээллийн сангийн мэдээлэл иргэд олон нийтэд нээлттэй юу? Хүссэн хэн ч хандах боломжтой юу?
- Мэдээллийн санд бүртгүүлээгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд ямар арга хэмжээ авах зохицуулалт байдаг вэ? Хэн хяналт тавьдаг вэ?

3.4 Сургалтын үнэлгээ, сэтгэгдэл

Нийт 12 асуулт бүхий сургалтын үнэлгээний хуудсыг боловсруулж оролцогчдоор үнэлгээ хийлгүүлсэн болно. Хэдийгээр 3 аймгийн 50 сумаас нийт 441 хүн сургалтад хамрагдсан хэдий ч үнэлгээний хуудсыг нийт 51 оролцогч буюу нийт оролцогчдын 12 хувь нь бөглөж сургалтын талаарх сэтгэгдлээ хуваалцав.

Хүснэгт 2-оос үнэлгээний зарим асуулт, хариултыг харж болохоос гадна зарим асуулт, хариултын хүрээнд тайлбар, сэтгэгдлийг орууллаа.

Хүснэгт 2. Үнэлгээний хуудасны нэгтгэл

№	Асуулт	Үзүүлэлт		
		Тийм	Зарим талаараа	Үгүй
1	Сургалтын зорилго тодорхой байсан уу?	37	13	1
2	Агуулгын бүтэц нь ойлгомжтой, уялдаа холбоотой байсан уу?	38	13	
3	Сургалтад хангалттай цаг хугацаа хуваарилагдсан байсан уу?	33	18	
4	Сургалт оролцоо, олон талт байдлыг хангасан байсан уу?	34	17	
5	Сургалтад ашигласан слайд, медиа материалууд нь сэдвийг ойлгоход хялбар болгосон уу?	41	10	
6	Сургалт таны хүлээлтийг хангаж чадсан уу?	32	19	
		Сайн	Дунд зэрэг	Муу
7	Сургагч багш нарын заах ур чадварыг үнэлнэ үү?	42	9	

8	Сургалт хэр сайн зохион байгуулалттай байсан бэ?	34	17	
9	Сургалтыг ерөнхийд нь хэрхэн дүгнэх вэ?	44	7	


Агуулгын бүтэц нь ойлгомжтой, уялдаа холбоотой байсан уу?, Сургалтад ашигласан слайд, медиа материалууд сэдвийг ойлгоход хялбар болгосон уу? гэсэн асуултуудад оролцогчдын дийлэнх нь “тийм” гэж хариулснаас дүгнэхэд сургалтын хөтөлбөр, агуулга оролцогчдод ойлгомжтой болсон байна гэж үзэж байна. Жишээ нь, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 3 дугаар багийн засаг дарга С.Байгаль “Сургалт хэрэгцээтэй байлаа, цар тахлын улмаас бид БОННУ-ний асуудлаар хурал, хэлэлцүүлэг хийгээгүй уджээ. Мэдээлэл ч хомс, сумын засаг даргаас л мэдээлэл авдаг байсан. Одоо бол өөрсдөө ойлголттой, мэдээлэлтэй болсон” гэж хэлсэн.

Сургалтын лекц ба бусад үйл ажиллагааны (дасгал ажил, сэргээх дасгал гэх мэт) тэнцвэрийн талаар та ямар бодолтой байна вэ? гэсэн асуултад нийт 51 оролцогчийн 49 нь лекц болон бусад үйл ажиллагааны аль алиных нь хэмжээ тохирсон гэж хариулсан.

График 5. Үнэлгээний хуудасны нэгтгэл



График 6. Сургалтын үр дүнгийн үнэлгээ



Цахим сургалт нь оролцогчдын одоогийн ажилд хэр хамааралтай вэ? гэсэн асуултад нийт оролцогчдын 31 нь “их хамааралтай”, 17 нь “дунд зэрэг хамааралтай” гэж хариулснаас үзэхэд сургалтад оролцох шаардлагатай хүмүүс нь хамрагдсан байна гэж дүгнэж болохоор байна.

Сургалтыг илүү үр дүнтэй болгохын тулд хэрхэн сайжруулах вэ? гэсэн асуултад дийлэнх оролцогчид сургалтыг танхимын хэлбэрээр

дахин явуулах, 3 оролцогч харилцан яриа, асуулт хариултын цаг нэмэх, 2 оролцогч иргэдийн төлөөлөл болон илүү олон хүмүүсийг хамруулах, харин 5 оролцогч кейс буюу бодит жишээн дээр мэдээлэл өгөх хэрэгтэй гэж хариулсан. Жишээ нь, Хархорин сумын байгаль хамгаалагч н.Болормаа “Манай суманд иргэдээс санал авалгүйгээр лиценз олгосон асуудал ихээр гардаг. Иргэд үүнд их эмзэглэдэг. Тиймээс энэ сургалтыг яг орон нутагтаа авмаар байна. Бодит байдлын жишээн дээр газар дээр нь сургалт хийх хэрэгтэй байна” гэж сэтгэгдлээ хуваалцсан юм. Үүнээс үзэхэд орон нутагт байгууллага, иргэд танхимын сургалтыг илүү үр дүнтэй бөгөөд оролцогчдын бодит оролцоо харагддаг гэж үздэг хэвээр байна гэж дүгнэж байна.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ИТХ-ын төлөөлөгч Идэрмөнх “Цахим сургалт их таалагдсан. Өөр өөр төлөөллүүд хамтдаа багийн ажил хийж ярилцсан. Энэ сургалтын ачаар бид олуулаа цугласан дээрээ асуудлуудаа ярилцаж чадсан” гэж хариулсан нь үнэлгээний хуудасны “Сургалт оролцоо, олон талт байдлыг хангасан байсан уу?” гэсэн асуултад 34 хүн “тийм” гэж хариулсныг бататгаж байна.

Нийт 51 хүний 44 нь сургалтыг ерөнхийд нь “сайн” гэж үнэлсэн учраас “БОННУ ба талуудын оролцоо” сургалтыг оролцогчдын хэрэгцээнд тулгуурласан сургалт боллоо гэж үнэлж байна.

3.5 Цахим сургалтын сорилт, бэрхшээл, суралцсан зүйлс

Сорилт бэрхшээл

1. Сургалтын зар мэдээллийг хүргэх ажлыг утсаар болон цахим хаягаар хүргүүлэх явцад утасны сүлжээ тасрах, утас нь холбогдохгүй байх, утасны дугаар өөрчлөгдсөн, цахим хаягаа буруу өгөх, хүргүүлсэн мэдээлэлтэй танилцахгүй байх зэргээс шалтгаалан цаг хугацаа алдах, дахин дахин холбогдож сануулах зэрэг хүндрэл бэрхшээл их гарсан.
2. Дэд бүтэц болон бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой засвар, үйлчилгээнээс шалтгаалан сум, багийн хэмжээнд цахилгаан, харилцаа холбоо, интернэтийг тасалсан, хязгаарласнаас оролцогчид цахим сургалтдаа бүрэн оролцож чадахгүй бэрхшээл Хэнтий аймагт 2 сум, Сүхбаатар аймагт 1, Өвөрхангай аймгийн 2 суманд тохиолдсон.

3. Мөн алслагдсан сум, багт харилцаа холбоо болон интернэтийн хурд муу, шаардлага хангахгүй төхөөрөмжтэй зэрэг шалтгаанаар, сургалтад оролцогчид байгаа газраасаа, өөрт байгаа тоног төхөөрөмжөөр цахим сургалтад оролцох боломжгүй тул аймгийн төв, сумын төв дээр цугларч оролцох шаардлага үүссэн. Үүнээс шалтгаалан зарим оролцогчдод замын зардал, дата худалдан авах зэрэг тодорхой хэмжээний зардал шаардагдсан.
4. Мэдлэг шалгах тест болон үнэлгээний хуудас бөглөх ихээхэн түвэг үүсгэж байна гэсэн саналыг олон оролцогч илэрхийлсэн. Үүнд, техник тоног төхөөрөмж хангалтгүй, цахим орчинд ажиллах дадлага туршлага багатай, мөн өмнө нь ийм төрлийн сургалтад хамрагдаж байгаагүй, БОННУ талаар ойлголт багатай тул танхимаар уг сургалтад дахин хамрагдмаар байна гэсэн тайлбарууд өгсөн.
5. Бусад яам, агентлаг орон нутгаас зохион байгуулж байгаа цаг үеийн ажил арга хэмжээнүүд /Тухайлбал: Мал тооллого, Хаврын тариалалт, Малчдын зөвлөгөөн, Тэрбум мод тарих аян болон Сүхбаатар, Архангай аймгуудад БОАЖЯ-наас зохион байгуулсан бүсчилсэн уулзалт зөвлөгөөнүүд/ давхацсантай холбоотойгоор бүртгэгдсэн оролцогчид цахим сургалтад бүрэн оролцоогүй. Өөр хүн орлуулах, сургалтын дундаас гарч явах зэрэг бэрхшээл нийтлэг тулгарсан.
6. Оролцогчдын төхөөрөмжийн хүчин чадал муугаас шалтгаалан оролцогчдыг бүгдийг камертай оролцуулах, оролцоог хянах боломж багатай байв. Энэ нь сургалтын үр дүнг тооцоход бэрхшээл үүсгэж байлаа.

Сургалтаас суралцсан зүйлс

- 1) Сургалтын үнэлгээний хуудаснаас дүгнэлт хийхэд дийлэнх оролцогчид “сургалтыг танхимаар авах” хүсэлт гаргасан байсан нь сургалтын сэдэв нь дадлага байдлаар хийх, дүрд тоглох, багаар ажиллах гэх мэт аргачлалыг шаардсан байсантай холбоотой байлаа. Жишээ нь, ИНХ-ын хэлэлцүүлэг зохион байгуулахтай холбоотой сургалтын өмнөх мэдлэгийн тестийн хариултаас харахад ихэнх нь мэдэхгүй, хариулаагүй байсан юм.
- 2) Төрийн байгууллагууд цар тахал болон төсвийн зардалтай холбоотойгоор танхимын сургалтаас илүүтэйгээр цахим сургалтыг дэмжиж байгаа. Гэхдээ төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтнууд сургалтын уламжлалт арга болох танхимын сургалтад дасан зохицсон учраас цахим сургалтыг үр дүн багатай гэж үзсээр байна. Энэ хэвшмэл байдлыг эвдэхийн тулд төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд, сургалт хариуцсан ажилтнууд төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран цахим сургалтын ач холбогдлыг ойлгуулах, цахимаар үр дүнтэй ажиллах зөвлөмжийг урьдчилан хүргэх, техник хэрэгслийг сайжруулах тал дээр анхаарах хэрэгтэй гэж үзлээ.
- 3) Нийт оролцогчдын 12 хувь нь л сургалтын үнэлгээний хуудсыг бөглөсөн хэдий ч тэдгээр хүмүүсийн үнэлгээнээс үзэхэд цахим сургалтын агуулгын хувьд хэрэгцээ, оролцогчдын хүлээлт их байсан нь харагдаж байна. Агуулгын бүтэц нь ойлгомжтой, уялдаа холбоотой байсан уу, сургалтад ашигласан слайд, медиа материалууд нь сэдвийг ойлгоход хялбар болгосон уу гэсэн асуултуудад дийлэнх нь “тийм” гэж

хариулсан байсан учраас сургалтын сэдвийн дагуу оролцогчид мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн гэж дүгнэж байна.

4 Мэдээллийн сангийн мониторингийн үр дүн

Байгаль орчны мэдээллийн сангаас туршилтын 3 аймагт хэрэгжиж буй болон хэрэгжих БОННУ тайлангаа батлуулсан төслүүдийн мэдээллийг дараах 11 үзүүлэлтээр шүүж нэгтгэв.

- БОННУ хийсэн байгууллагын нэр
- Үнэлгээ хийсэн чиглэл
- Тайлан батлагдсан огноо
- Тайлангийн дугаар
- Төслийн нэр
- Төсөл хэрэгжих аймгийн нэр
- Төсөл хэрэгжих сумын нэр
- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан
- Байгаль орчны аудитын тайлан

Нийтдээ Хэнтий 181, Өвөрхангай -197, Сүхбаатар 196 БОННУ-ний тайлан Байгаль орчны мэдээллийн санд тавигдсан байна. Үүнээс сүүлийн 5 жилийн байдлаар Хэнтий-46, Өвөрхангай -32, Сүхбаатар -31 төслийн БОННУ батлагдаж, мэдээллийн санд оржээ.

Байгаль орчны хуулиудаар төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутагт хүлээлгэж өгөх үүрэгтэй баримт бичгүүдийн бүрдлүүдийг гаргаж, тулгах ажил хийхэд дараах үр дүн гарч байна.

БОННУ-ний мэдээллийн санд 2017-2022 онд Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймагт хэрэгжиж байгаа нийт 108 аж ахуйн нэгжийн БОННУ болон БОМТ, БОМТ-ний тайлан тухайн орон нутгийн бүртгэлийн сан, хяналтад байгаа эсэх мэдээллийг нягталж үзлээ. Дээрх мэдээллийг сумдын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагч, сонгогдсон аймгуудын БОАЖГ-аас авч нэгтгэв.

Судалгаанд 3 аймгийн 98 аж ахуйн нэгжийн (судалгаанд хамрагдах зохих аж ахуйн нэгжийн 90.7 хувь) мэдээллийг нэгтгэсэн. Хэнтий аймгийн 4 сумын 10 аж ахуйн нэгжийн мэдээлэл нь тухайн сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагч нар Өмнөдэлгэр суманд нэгдсэн сургалтад хамрагдаж байгаа гэсэн шалтгаанаар судалгаа ирүүлээгүй.

Судалгаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч мэдээллийн санд бүртгүүлээгүй төслүүд байна. Энэ нь Хэнтий аймаг-1, Сүхбаатар аймаг-4, Өвөрхангай аймаг-2, нийт 7 аж ахуйн нэгж байна.

Судалгаанд хамрагдсан Хэнтий аймгийн 34, Сүхбаатар аймгийн 32, Өвөрхангай аймгийн 32, нийт 98 аж ахуйн нэгжийн БОННУ болон БОМТ, БОМТ-ний тайлангийн судалгааг авч үзэхэд дараах үзүүлэлт харагдаж байна. Үүнд:

1. БОННУ байгаа эсэх асуулгад нийт 98 аж ахуйн нэгжийн 35 аж ахуйн нэгжийн БОННУ байгаа, 63 аж ахуйн нэгжийнх байхгүй байна. Сумдад байх ёстой БОННУ-ний 35.7 хувь нь байна.
2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө байгаа эсэх асуулгад 98 аж ахуйн нэгжээс 17 буюу 17.3% нь байгаа, 11 аж ахуйн нэгжийнх дутуу, 70 аж ахуйн нэгж буюу 71.4% нь байхгүй байна.
3. БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан байгаа эсэх /жил бүрээр/ асуулгад 98 аж ахуйн нэгжээс 17 аж ахуйн нэгж тайлангаа ирүүлсэн, 8 аж ахуйн нэгж дутуу ирүүлсэн, 73 аж ахуйн нэгж буюу 74.4% нь тайлангаа ирүүлээгүй байна.

Эндээс БОННУ болон БОМТ, БОМТ-ний тайланг орон нутагт бүрэн хүлээж авдаггүй зөрчил нийтлэг байна.

Мэдээллийн сангийн мониторинг, баримт бичгүүдийн бүрдлийг хавсаргав.

5 Эрх зүйн орчныг сайжруулах, зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмж

БОННУ ба ИНХ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.8-т заасны дагуу болон 18.4-т заасны дагуу “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл”-ийг тусгах, 18.4-т “төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж заасан байна.

Дээрх хуулийн 8.4.8-д заасан Иргэдийн нийтийн хурлын (ИНХ) үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиар хийдэг. Ингэхдээ ИНХ буюу нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх үндсэн шаардлагуудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Иргэн ИНХ-д саналын эрхтэй оролцох, хурлын дэг, хуралдааны дарга сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх, огцруулах, Засаг даргын тайланг хэлэлцэх,
- Тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлыг ИНХ-д хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр санал гаргах,
- Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах гэх мэт.

Дээрхээс харахад ИНХ нь хуулиар олгосон тодорхой хэм хэмжээ, асуудлын хүрээнд нутаг дэвсгэрийн хүрээнд нийгэм, эдийн засгийн асуудлыг хэлэлцэж, **шийдвэр** гаргах үүрэг бүхий иргэдийн оролцоонд суурилсан байгууллага байна. Гэтэл Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.8, 18.4 дүгээр заалтуудад зөвхөн иргэд, нийтээс тухайн БОННУ тайланд шийдвэр гаргуулах бус зөвхөн тайланд санал авах тухай заасан байдаг. БОНБУ тухай хуульд ИНХ-аар хэлэлцүүлж, **санал авах** зохицуулалт оруулсан нь өөрөө “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль болон ИНХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны талаар төдийлөн ойлголтугүйгээр, тодорхой бус зохицуулалт хийсэн нь харагдаж байна. Түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллага буюу ИНХ-аар дамжуулж БОННУ-ний тайлангийн төслийг хэлэлцдэг зохицуулалт зөвхөн Монгол Улсад байгаа нь олон улсын зарчмаас гажсан, БОННУ тайланд олон нийтээс санал авч тайлангийн чанарыг сайжруулах, иргэдийн шийдвэр гаргалтад чөлөөтэй оролцох эрхийг хангахад хүндрэл учруулж байгаа асуудлыг үүсгэж байна.

Иймд, БОНБУ хуулийн 8.4.8, 18.4 дүгээр заалтуудыг өөрчлөн найруулж, ОУ-ын зарчимд нийцүүлэх, БОНБУ дэх олон нийтийн оролцоог хангах журмыг сайжруулж, хэзээ, хэрхэн иргэдийн ямар арга хэлбэрээр оролцоулах зохицуулалтыг дахин нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Мөн БОННУ дэх иргэдийн оролцоог төслийн хүчин чадал, төрөл, нөлөөлөлд үндэслэн ялгаатай байдлаар хангах зохицуулалт хийх шаардлага бий. Тухайлбал, жижиг төслүүдийн хувьд заавал олон нийтийн хурал, хэлэлцүүлэг хийлгүй мэдээллээр хангах байдлаар оролцоог хангах, дунд хэмжээний төслүүдэд иргэдийн хэлэлцүүлэг хийж санал

авах, томоохон төслүүдийн хувьд иргэдийг олон үе шаттай оролцуулах, иргэдийг мэдээллээр хангах, төслийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх семинар, сургалт хийх, хэлэлцүүлэг хийх байдлаар ялгаатай зохицуулалт хийж болно.

“Олон нийтийн оролцоог хангах аргачлал”

БОНБУ дэх олон нийтийн оролцоог хангах журмын хэрэгжилт дутмаг байгаа талаар өмнөх тайланд бид дурдсан билээ. Үүнтэй холбоотойгоор олон нийтийн оролцоог хангах аргачлалыг боловсруулж мэргэжлийн байгууллага болон орон нутгийн асуудал хариуцсан албан хаагчдад таниулж, БОНБУ-д олон нийтийн оролцоог хангах ажлыг бүх түвшинд жигдрүүлэх шаардлагатай байна.

Боловсон хүчний мэдлэгийг бэхжүүлэх

Сургалтад оролцсон албан хаагчдаас мэдлэг шалгах тест авахад нийт хариултын 72% нь буруу, 28% нь зөв байгаа нь орон нутгийн албан хаагчдын БОННУ-ний талаарх мэдлэг муу байгааг илтгэж байна. Энэ нь орон нутгийн түвшинд БОННУ-ний талаарх мэдээлэл, сургалт хангалтгүй, төрийн алба боловсон хүчнийхээ чадавхийг бэхжүүлэх, хувь хүний хөгжлийн асуудалд хөрөнгө оруулахгүй байгаатай холбоотой байж болох юм. Нөгөө талдаа сум, багийн сонгуульт албан тушаалтнууд болон мэргэжилтнүүд ихээр солигддог нь удаах шалтгаан байж болно. Хэдий тийм ч шинээр ажилд томилогдсон асуудал хариуцсан албан хаагчдаа БОННУ болон иргэдийн оролцооны талаар сургалтад суулгах, шинэлэг мэдээллээр хангах, хууль эрхзүйн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

БОАЖЯ:

Асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зүгээс салбарын хэмжээнд БОННУ-ний оролцогч талуудад хууль тогтоомжоо сурталчлах, хэрэгжилтийг зөв чиглүүлж, удирдамжаар хангаж ажиллах шаардлагатай байна. Мөн мэргэжлийн холбоо, байгууллага, ОУ-ын донор байгууллагуудтай хамтран улсын хэмжээнд 2 жил тутам цуврал сургалт, семинар, орон нутгийн албан хаагчдыг чадавхжуулах ажлыг зохион байгуулж хэвших хэрэгцээ байна.

Аймгийн БОАЖГ:

Орон нутгийн хэмжээнд төсөл хэрэгжүүлэгч, сумдын ЗДТГ, багуудын ИНХ-д БОННУ-ний талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалтын үйл ажиллагаа тогтмол хийж, орон нутгийн албан хаагч, иргэдэд БОННУ-ний талаар бодит, зөв мэдээллээр хангаж ажиллах шаардлагатай байна.

Сумын ЗДТГ:

Сумын хэмжээнд албан хаагчид, иргэддээ БОННУ-ний талаарх мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх, шинээр ажилд орж буй болон сонгогдож буй төлөөлөгчдөө БОННУ-ний талаар хууль эрх зүйн сургалт хийж, ойлголтын зөрүүг арилгах. Багуудын ИНХ-ийн Даргалагч, Засаг даргыг чадавхжуулахад идэвх гарган ажиллах.

БОННУ-ний тайлангаа батлуулсан төслүүдийн мэдээлэл орон нутгийн бүртгэлийн сан, хяналтад байгаа эсэхтэй холбоотойгоор

- БОНБУ-ний тухай хуулийн 8 дугаар зүйл, 8.7-д “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь хээрийн судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг дөрвөн хувь бэлтгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжүүлэгч болон төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт тус бүр нэг хувийг өгч, нэг хувийг өөртөө үлдээх бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна.” гэж заасан байдаг. Байгаль орчны мэдээллийн сангаас цахим сургалт зохион байгуулсан Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай 3 аймгийн хэмжээнд БОННУ-ний тайлангаа батлуулсан төслүүдийн мэдээлэл орон нутгийн бүртгэлийн сан, хяналтад байгаа эсэхийг шүүж үзэхэд Орон нутгийн ЗДТГ-т батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэг хувийг хүргүүлэхгүй байгаа нь нийтлэг ажиглагдлаа. БОНБУ-ний тухай хуулийн 8.7-д заасан үүргээ үнэлгээний мэргэжлийн байгууллагууд зөрчиж байгаа бөгөөд уг зөрчлийг яаралтай таслан зогсоох шаардлагатай нь харагдаж байна.
- Дээрх асуудалтай холбоотой хяналтын зохицуулалтыг тус хуулийн 8.8-д “Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина” гэж тусгасан байдаг ч үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байгаа нь дээрх судалгааны дүнгээс харагдаж байна.
- Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.9, 8.6.10 дахь заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалтын хэрэгжилтийг сайжруулах, иргэдийн мэдэх эрхийг хангахын тулд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:
 1. БОАЖЯ-наас сум, орон нутагт БОННУ-ний тайлан болон тухайн жилийн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг хүлээж авах, орон нутагт нэгдсэн мэдээллийн “бааз” үүсгэх талаар чиглэл өгөх,
 - Ингэхдээ БОННУ, БОМТ, БОМТ хэрэгжилтийн тайланг эх хувиар нь нэгтгэн, нийтэд ил байдлаар хадгалах,
 - Дээрх тайлангуудыг цахим хэлбэрээр хадгалах, цахим бүртгэл үүсгэх,
 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад нэгдсэн чиглэл өгч БОНБУ тухай хуулийн 8.7-р заалтыг хэрэгжүүлэхийг сануулах, батлагдсан БОННУ тайлангаа тухайн төсөл хэрэгжих сумын ЗДТГ-т хүргүүлээгүй ААН-үүдийг нөхөж хүргүүлэхийг шаардах,
 3. Тухайн жилийн БОМТ, БОМТ хэрэгжилтийн тайлангаа сум, орон нутагтаа хүргүүлээгүй төсөл хэрэгжүүлэгчдэд дээрх баримт бичгийн хувийг орон нутагтаа нөхөн хүргүүлэх тухай мэдэгдэл хүргүүлж, хуулийн арга хэмжээ авах тухай сануулга өгөх,
 4. БОНБУ тухай хуулийн 8.8 дахь заалтын дагуу үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудад хуулийн зохицуулалтын талаар сургалт, мэдээллээр хангаж ажиллах,
 5. Тус судалгаатай адил хяналтын судалгааг бусад аймаг, сумуудад хийж, хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарах,

6. БОНБУ тухай хууль болон дагаж гарсан дүрэм, журамд талуудын эрх үүрэг, хариуцлагын механизмыг дэлгэрэнгүй тусгах,

6 Хавсралт

6.1 Гарын авлага

6.2 Оролцогч талуудын жагсаалт

6.3 Цахим сургалтын модуль

6.4 Цахим сургалтын хөтөлбөр

6.5 Цахим сургалтад оролцогчдын жагсаалт

6.6 Мэдээллийн сангийн мониторинг

